



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 5/32

Чингис хот

Д.Энхтуяаг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.3 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.2, 23.2.3, 24.1 дэх заалт, "Төсвийн байгууллагын зарим ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай" Засгийн газрын 2003 оны 233 дугаар тогтоол, Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр", "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2017 оны 04 дүгээр тогтоол, Архивын Ерөнхий газрын даргын 2019 оны А/01 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архивын тасгийн цахим архивч-операторч Ц.Мягмар-Ариунаагийн жирэмсэн болон амаржсаны хугацаанд цахим архивч-операторчоор Дамдингийн Энхтуяаг 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрөөс томилсугай.

2. Цахим архивч-операторч Д.Энхтуяагийн сарын үндсэн цалинг ТҮ-4-1 шатлалаар, хоол унааны зардлыг 5000 төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-т зөвшөөрсүгэй.

3. Хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Л.Бат-Октябрь/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР